



МОНЭС


МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН

6

2006 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

Биднийг дэмждэг байгууллагуудад

ТАЛАРХАЛ ДЭВШҮҮЛЬЕ!



GLOBAL FUND
FOR WOMEN

filia
● die frauenstiftung.


Iara Lee & George Gund Foundation



grantmakers
WITHOUT BORDERS




WOMEN'S FUNDING NETWORK
CHANGING FACE OF PHILANTHROPY



BRITISH EMBASSY



stiftung
natur
mensch
KULTUR


TIDES
FOUNDATION

**URGENT
ACTION
FUND** ♀

FOR WOMEN'S HUMAN RIGHTS

Агуулга

1. Мэндчилгээ	4
2. МОНЭС-ийн Эрхэм зорилго	5
· Тэтгэлэг олгох хөтөлбөр	
· Сан бүрдүүлэх хөтөлбөр	
· ОУ-ын гишүүнчлэл буюу ОУ-ын сүлжээ	
3. Тэтгэлэг олгох хөтөлбөр	6
· Амжилттай хэрэгжсэн төслүүдээс	
· 2006 оны тэтгэлэгийн санхүүжилт	
4. Сан бүрдүүлэх хөтөлбөр	12
· Хөтөлбөрийн танилцуулга	
· Дотоодын хандив	
· Филантропи үйл ажиллагаа	
5. Байгууллагын танилцуулга	14
· МОНЭС-ийн хамт олон	
· МОНЭС-ийн ажилтанууд шагнал хүртэв	
· Сайн Дурын Гишүүд	
6. Өргөмжлөл	16
7. Санхүү	17
8. Хандивлагчдын нэрс	18
9. Хандив өргөх хуудас	22



МОНЭС

Эрхэм зорилго:

Монголын эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө нөөц хөрөнгийг хуримтлуулж санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Монголын Эмэгтэйчүүдийн Сан (МОНЭС) 2000 онд байгуулагдсан ба улс төрийн нам, эвслээс хараат бус, ашгийн төлөө бус Төрийн бус байгууллага /ТББ/ юм.

МОНЭС нь нийгэмд үйлчилдэг Эмэгтэйчүүдийн ТББ, эмэгтэй удирдагчтай хүний эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг ТББ болон үүсгэл санаачлагын бүлгүүдээс ирүүлсэн төслийн саналыг шалгаруулан санхүүгийн дэмжлэг үзүүлдэг филантропи (нийгмийн хөгжлийн төлөө санхүүгийн дэмжлэг үзүүлэх) байгууллага юм.

Хөтөлбөрүүд:

1. ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР:

Энэ хөтөлбөрийн зорилго нь эмэгтэйчүүдийг чадавхижуулах (empowerment) замаар нийгмийн өөрчлөлт хийх явдал юм. Үүний тулд дараахь зорилгын төслүүдийг санхүүжүүлнэ.

- Эмэгтэй лидерүүдийг чадавхижуулж ЭТББ, бүлгийг бэхжүүлж, эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хөгжил дэвшилд өөрчлөлт гаргах,
- Эмэгтэйчүүдийн идэвхитэй оролцоотой бодлогод нөлөөлж нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх,
- Эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш эрхийг хангахад чиглэсэн бодлого, хууль тогтоомж болон тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулах,
- Хөдөөгийн болон эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг хөгжүүлэх замаар тэдний статусыг дээшлүүлэх,

2. САН БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР:

Энэ хөтөлбөрийн зорилго нь нийгэмд үйлчилдэг Эмэгтэйчүүдийн ТББ ба бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж иргэд, байгууллагаас “хандив өгөх” үзэл хандлагыг төлөвшүүлэх явдал юм.


Үүний тулд:

- Филантропи үзэл хандлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх
- Сан бүрдүүлэх олон талт ажлуудыг зохион байгуулах,

ОУ-ын гишүүнчлэл буюу ОУ-ын сүлжээ

МОНЭС үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн дараахи Олон улсын Сүлжээний гишүүн байгууллага болоод байна.

- ОУ-ын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ /INWF/
- Америкийн Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ /WFN/
- Азийн Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ /AWFN/
- Хил хязгааргүй санхүүжилт олгогчдын Сүлжээ /GWOB/
- Хөгжлийн төлөө Эмэгтэйчүүдийн Олон Улсын Холбоо /AWID/
- Хүний эрхийн сангуудын Сүлжээ /HRFN/







2006 онд 88 төслийн санал хүлээн авснаас 31 төсөлд нийт 47 836 600 төгрөгийн санхүүжилт олголоо.

Бид 2006 онд дараахи чиглэлээр санхүүжилт олгосон. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр 16 төсөл буюу нийт тэтгэлэгийн 53%
- Эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулах чиглэлээр 10 төсөл буюу 34%
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр 5 төсөл буюу 14 % байна.



2001-2006 онд буюу 6 жилийн хугацаанд ЭТББ, бүлгүүдийн 115 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 216 сая төгрөгийн санхүүжилт хийлээ.



ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР

Амжилттай хэрэгжиж буй төслүүдээс

Засаглалд шударга ёсыг бий болгон бэхжүүлэх нь эмэгтэйчүүдийн идэвхитэй оролцоогүйгээр хийх боломжгүй юм. Иймд эмэгтэй манлайлагчдыг бэлтгэх, тэдний идэвхийг сэргээж чадваржуулах нь бидний зорилго юм.



“Эмэгтэйчүүдийн нүдээр- эмэгтэйчүүдийн хүчээр” Үндэсний Бага хурал

“1990 оноос эхэлсэн ардчилсан өөрчлөлтүүдэд сайн зүйл их байвч өнөөгийн улс төрийн байдал тийм ч таатай биш байна. Улс төрийн хариуцлага алдагдсан, намууд ардчилалгүй, эрх мэдэлтнүүд төрийн үйл хэргийг наймаалцдаг болсноос засаглалын гажуудал хэрээс хэтэрч коррупци, ядуурал, хүний эрхийн зөрчил хавтгайрч байна.

Иймд Иргэний нийгмийн байгууллагууд бид эмэгтэйчүүдийн идэвхитэй оролцоотой сайн зохион байгуулагдан улам өргөн хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулан хамтын хүчээр энэ шударга бус байдалтай тэмцэх нь зүйтэй байна” гэж онцлон тэмдэглэсэн энэ бага хурлыг МОНЭС-ийн санхүүжилтээр хийгдсэн “Эмэгтэйчүүдийн нүдээр - эмэгтэйчүүдийн хүчээр” Үндэсний Бага хурлыг Монголын ЭТББ-ын Үндэсний Сүлжээ зохион байгуулсан. Бага хуралд иргэний нийгмийн 50 гаруй байгууллагууд идэвхитэй оролцож 2 жилийн хамтын ажиллагааны төлөвлөгөө гарган хамтран ажиллахаар болсон юм.

Уул уурхайн салбарын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, үүнд эмэгтэйчүүдийн оролцоог хангах

“Иргэдийн мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэхийн тулд иргэдийн, ялангуяа эмэгтэйчүүдийн оролцоог хангах шаардлагатай байгаа юм. Жишээ нь орон нутгийн иргэд өөрсдийн эрх ашгийн эсрэг шийдвэр гаргасан орон нутгийн удирдлага, ИТХ-ын Тэргүүлэгч нарт хариуцлага тооцох зарчмууд хуулинд төдийлөн хангагдаагүй байна.” гээд “Газар хувьчлал болон ашигт малтмалын хуулийг хэрэгжүүлэхдээ кампаниуд нутгийн удирдлагуудтай хуйвалдан их хэмжээний алтны олборлолт хийснээс хөдөө орон нутагт мянга мянган га бэлчээрийн талбай эвдэрч, олон зуун гол горхи, булаг шанд, нуур цөөрөм ширгэж үгүй болон олон зуун малчин өрх орон нутгаасаа дайжин хот суурин бараадсан их нүүдэлд нэгдэж байна.” гэж Хүний эрх Хөгжил төв үзэж байна. Тэд “Монголын уул уурхайн салбарын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, ашигт малтмалын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, шийдвэр гаргагчдад нөлөөлөх түүнд эмэгтэйчүүдийн оролцоог хангах” энэ төсөлдөө тэмдэглэжээ.

Эмэгтэйчүүдийн оролцоо, эрхийг хамгаалах

“Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн эрх ашиг алхам тутамд хөндөгдөж, эмэгтэйчүүдийг дорой, буурай гэж үзэх, хүйсээр ялгаварлан гадуурхах, нэр хоч өгөх, эмэгтэйчүүд гарч болохгүй уул овоо, тахилга сүлд олноор бий болж, эмэгтэйчүүд ямагт хүний эрх мэдэлд, бусдаас ямагт хараат байх ёстой мэтээр ярьж хэлдэг болсон байна. Эмэгтэй удирдагчтай байгууллагын ажил “илүү сайн байна” гэж дүгнэдэг ч эцсийн үнэлгээний үед холдон бүдгэрч бүр ярихаа больсон. Эмэгтэйчүүдийн ажлыг үнэлэхээсээ илүү өөлөх муучлах байдал илт ажиглагдаж байна.” гэж Завхан аймгийн ЭТББ-дын “Эмэгтэйчүүдийн оролцоо, эрхийг хамгаалах” төсөлдөө дурьджээ. Энэ төсөл нь орон нутагт эмэгтэй манлайлагчдыг бэлтгэх, тэднийг чадваржуулах засаглалд шударга ёсыг бэхжүүлэхэд эмэгтэйчүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлж, бодлогод нөлөөлөх ажлыг зохион байгуулж байна. МОНЭС энэ төслийг санхүүжүүлснээс гадна Завхан аймгийн манлайлагч эмэгтэйчүүдийг сургаж бэлтгэсний үр дүнд тус аймагт “Өрнөх хөгжил” ЭТББ-ын сүлжээ байгуулагдан үр дүнтэй ажиллаж эхлээд байна.



Ажлын байран дахь бэлгийн дарамтлал

"...бэлгийн дарамтлал хувь хүний дархан байдал, ажилтануудын аж байдал аюул занал учруулж ажлын байран дахь эрх тэгш байдлыг үгүй болгож хөдөлмөрийн харилцааны үндэс суурийг сулруулж үйлдвэрлэлийг бууруулдаг. Үүний ноцтой үр дагавар хөнөөлийг харгалзан улс орнууд иргэний болон эрүүгийн хариуцлага ногдуулах эрх зүйн актыг батлан гаргах боллоо."



"Ажлын байран дахь бэлгийн дарамтлал" /АББД/-тай тэмцэх явдал МОНЭС-ийн анхаарлын төвд байдаг.

Хөдөлмөр эрхлэлтэнд ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 111-р конвенциас...

88 өдрийн хөрөнгө босгох аянаар хуримтлуулсан 10,7 сая төгрөгний хандивын мөнгөөр "Stop Sexual Harassment"-1,2, "АББД-ыг сэтгүүлчдэд таниулах нь", "АББД-ын талаархи эрх зүйн орчинг бүрдүүлэх", "АББД хүний эрхийн зөрчил болох нь" төслийг санхүүжүүллээ. Эдгээр төслүүдийг Хөгжлийн Ниссора сан, Эмэгтэй удирдагч сан, ТББ-дын Эвсэл, Хуульч Эмэгтэйчүүдийн холбооныхон амжилттай хэрэгжүүлээд байна.

Төслийн үр дүнд:

- АББД-тай тэмцэх 15 ТББ-ын оролцоотой Эвсэл байгуулагдав.
- Хуульчдын баг бий болж Хөдөлмөрийн хуулийг сайжруулах хүрээнд 10 орчим хуульд нэмэлт оруулах хуулийн санал боловсруулаад байна.
- Хот хөдөөгийн сэтгүүлчдэд сургалт явуулж "Сэтгүүлчдийн бүлэг" байгуулагдав.
- Мөн энэ ажлын хүрээнд сургагч багшийн болон хууль боловсруулагч нарт зориулсан гарын авлагууд гарлаа.
- Олон нийт болон хууль боловсруулагчдад нөлөөлөх кампанит ажлуудын хүрээнд ТББ-ууд, МҮЭХ, БСШУЯ, НХХЯ, Дээд шүүх зэрэг байгууллагуудын нөлөө бүхий 75 орчим мэргэжлийн хүмүүст сургалт, уулзалт хэлэлцүүлгийг хийсэн ба тэд бидний үйл хэргийг дэмжиж ажиллахаа илэрхийлж байна.

Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг чадваржуулах

Хар тамхи мансууруулах бодисоос иргэдээ хамгаалах нийгэмлэгээс ирүүлсэн “Архигүй орчинд амьдарцгаая”, “Амьдрах сайхан” төслүүдийг МОНЭС санхүүжүүлээ.

Төсөлд хотын захын хорооны 30-58 насны архины гүн хордлогод орсон 16 эмэгтэй, давхар хамааралтай 4 эмэгтэйг өөрсдийнх нь зөвшөөрсний дагуу хорт зуршлаас гарах сургалтанд хамруулсны үр дүнд 17 эмэгтэй архинаас гарч, тэдний гэр бүлийн 34 хүний амьдралд эерэг өөрчлөлт гарсан. Тэд эхлээд бүгд айж эмээсэн, болгоомжилсон байдалтай ирж байсан бол сургалтын төгсгөлд ганцаараа асуудлаас гарах гэж тэмцсэнээс хамтран ажиллах нь илүү үр дүнд хүргэдэг юм байна гэж чин сэтгэлээсээ талархаж байв.

Мөн төсөлд хамрагдсан эхний 10 эмэгтэйд гоёл, чимэглэл хийж сурах сургалтын хичээл явуулсаны үр дүнд орлогоо нэмэгдүүлэх боломжтой боллоо.



Төсөлд хамрагдсан эмэгтэйчүүдийн ярианаас :

Эмэгтэй “Б” хэлэхдээ:

Би урьд нь маш олон жил тасралтгүй архи ууж байсан ч энэ муу зуршлаасаа гарч чадахгүй байсаар олон жилийг ардаа орхижээ. Харин МОНЭС-ийн дэмжсэн энэ сургалтанд суусны хүчинд муу зуршлаасаа саллаа. Архи уудаг өөр олон хүмүүсийг энэ төсөлд хамруулаасай гэж хүсэж байна. Цаашид ч хамтран ажиллахад бэлэн байна.

Эмэгтэй “Д” хэлэхдээ:

Би энэ сургалтанд сууснаар их зүйл сурлаа. Одоо би хань, үр хүүхдээ хайрлах, уучлах сэтгэлийг мэдэрлээ. Би гэр орондоо үлгэр дуурайлтай амьдарч архи уухгүй гэдгээ баталж байна.

Нийгмийн хөгжлөөс хоцрогдож буй эмэгтэйчүүдийн эрх, тэдний статусыг дээшлүүлэхэд санаа тавьж ажиллах нь МОНЭС-ийн бас нэг чиглэл юм.

Энд

- хөдөөгийн эмэгтэйчүүд
- хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд,
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээжүүд,
- хүүхэд төрүүлсэн насанд хүрээгүй охид,
- архинд донтсон эмэгтэйчүүд,
- 35-аас дээш насны олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд,
- хүчирхийллийн улмаас гэрээсээ дайжсан охид, хүүхдүүд

Дээрхи бүлгүүдтэй ажилладаг ТББ-дад, нийт санхүүжилтийн 50 гаруй хувийг зарцууллаа.



**“Ирээдүйн гарц” холбоо ТББ-ын
“Тэгш амьдрал” төсөл**

Баянзүрх дүүргийн 10 дугаар хороонд хэрэгжсэн уг төслөөр хотын захын хорооллын амьдралын түвшин доогуур, олон хүүхэдтэй, эмзэг бүлгийн эмэгтэйчүүд, тэдний нөхөр, хүүхдийг оролцуулсан амьдрах ухааны шат дараалсан сургалтууд явуулсны үр дүнд хямд төсөр материалаар янз бүрийн бүтээгдэхүүн хийж орлогоо нэмэгдүүлэх чадвартай болж түүгээр ч зогсохгүй гэр бүлдээ тохиолдож байгаа бэрхшээлтэй асуудлаа хамтран шийдвэрлэх чадвартай боллоо.



2006 оны тэтгэлэгийн санхүүжилт

1. Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр

Байгууллагын нэр	Төслийн нэр, зорилго	Төсөв
Монголын ЭТББ-ын Үндэсний Сүлжээ	Эмэгтэйчүүдийн нүдээр Эмэгтэйчүүдийн хүчээр Иргэний нийгмийн байгууллагуудын Үндэсний Бага хурал	2 522 200
Цэргийн ба цэрэгжсэн эмэгтэйчүүдийн "Бэрцэцэг" холбоо	Эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдал сургалт, гэгээрлийн ажил	940 100
"Нээлтэй академи" ТББ	Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөлд өгөх санал боловсруулах	300 000
Хөгжлийн "Нисора" сан	АББД-ыг зогсоох төлөө сургагч багш бэлтгэх сургалтын	891 500
Эмэгтэй Удирдагч Сан	АББД-ын асуудлаар сэтгүүлчдийн бүлэг байгуулах "Хаалганы цаана нээлттэй мэдээлэл" төсөл	2 000 000
Ардчиллын Боловсрол Төв	ТББ-ын татвартай холбоотой асуудлаар Нөлөөлөлийн үйл ажиллагаа явуулах	500 000
"САПУ" түрээслэгчдийн ҮЭХ	Хохирогчдод эрх зүйн мэдээлэл олгох Уулзалт зохион байгуулах	300 000
ХЭҮТ	Хохирогч эмэгтэйн эрхийг хамгаалах	3387200
ХБЭҮТөв	Хөгжлийн бэрхшээлтэй Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаархи Үндэсний Бага хурал	175000
Хүний эрх, хөгжил төв	Орон нутгийн Засаглалд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	5800000
АББД-ын эсрэг хуульчдын бүлэг	Хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах	2336000
Завхан аймгийн ЭТББСүлжээ	Эмэгтэйчүүдийн оролцоо, эрхийг хамгаалах	6 000 000
Эмэгтэй сэтгүүлчдийн бүлэг	Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг олон нийтэд түгээх	1 000 000
АББД-тай тэмцэх ЭТББ-ын эвсэл	АББД-ын эсрэг хууль тогтоомжийн төлөө нөлөөлөлийн ажил	2 500 000
Хуульч эмэгтэйчүүдийн холбоо	АББД-ын эсрэг хууль тогтоомжийг сайжруулах	1 500 000
Хууль ба Хүний эрх	Хохирогч эмэгтэйн эрхийг хамгаалах	1 868 800
Дүн		32 020 800

2. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулах чиглэлээр

Гар урлалыг хөгжүүлэх "Дүүрэн Санаа" сан	Төв аймгийн 3 сумын эмэгтэйчүүдэд эсгий урлал хийж сурах "Хот айл" төсөл	1 086 000
ЛЭОС-ын Баян-Өлгий аймгийн салбар зөвлөл	Баян-Өлгий аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхчүүд нарийн боов хийж сурах төсөл	710 000
ХУД-ийн 15-р сургуулийн багш, сурагчдын бүлэг	Хөгжлийн бэрхшээлтэй охидыг техниктэй ажиллаж сурахад туслах	600 000
"Ирээдүйн гарц" холбоо	Хотын захын эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд туслах "Тэгш амьдрал" төсөл	500 000
ХУД-ийн 1-р хорооны эмэгтэйчүүдийн бүлэг	Ажилгүй өрх толгойлсон эмэгтэйчүүдийн орлого нэмэгдүүлэх "Эв эе" төсөл	500 000
ХУД-ийн 4-р хорооны эмэгтэйчүүдийн "Чадамж" бүлэг	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг сургаж орлого нэмэгдүүлэх "Чадамж" төсөл	300 000
Хар Тамхи, Мансууруулах Бодисоос Иргэдийг Хамгаалах Нийгэмлэг	Архинд гүн хордсон эмэгтэйчүүдийг нийгэмшүүлэх "Архигүй орчинд амьдарцаага" төсөл	600 000
ХТМБИХН	Архинд гүн хордсон эмэгтэйчүүдийг нийгэмшүүлэх "Амьдрах сайхан" төсөл	1200 000
Ховд аймгийн Мянгад сумын Эмэгтэйчүүдийн бүлэг	Сүүгээр шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж сурах "Сүү шим" төсөл	2 400 000
Төв аймгийн Угтаал сумын Эмэгтэйчүүдийн бүлэг	Малчин эмэгтэйчүүдийг малжуулах Орлого нэмэгдүүлэх төсөл	340 000
Дүн		8 236 000

3. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр

ЭТББ-дын Үндэсний Сүлжээ	ЭТББ-уудын мэдээлэл солилцооны хөтөлбөрийг сайжруулах	1 500 000
Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах "ГҮНЖ" төв	Зүүн Азийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт	700 000
Төв аймгийн Эмэгтэйчүүдийн Зөвлөл	Зүүн Азийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт	700 000
ХЭҮТ	Өсвөр үеийнхэний Хамгаалах байр	3 207 700
Завхан ЭТББ-д	Орон нутгийн Манлайлагчийг сургах сургалтын аялал	1 472 000
Дүн		7 579 700
Нийт		47 836 500



Дотоодын хандив

2006 дотоодод 10,6 сая төгрөгний сан бүрдүүлсэн бөгөөд 836 хандивлагчидтай болсон ба үүний 631 хувь хүмүүс, 206 байгууллага байна.

Танилцуулга:

МОНЭС нийгэмд үйлчилдэг ЭТББ болон бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжихийн тулд дотоод, гадаад эх үүсвэрээс мөнгөн сан бүрдүүлдэг.


Энэ хөтөлбөрийн хүрээнд үүний тулд Бид нийгмийн хөгжлийн төлөө халуун сэтгэлийн гараа сунгаж хандив өргөх Филантропи үзэл хандлагыг Монголын нийгэмд төлөвшүүлэх замаар иргэд, байгууллагуудаас хандив цуглуулах олон талын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

- Бид Азийн Эмэгтэйчүүдийн Сангуудтай хамтран 88 өдрийн сан бүрдүүлэх аянг зохион байгууллаа.
- 11 сард хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран олон нийт филантропи үзэл хандлагыг түгээн дэлгэрүүлэх, сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан.
- 35-аас дээш насны ажилгүй эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор Хаан банктай хамтран хандив цуглуулах ажлыг явуулж байна.

Байгуулагдсанаасаа хойш нийт 3052 хандивлагчтай болсон ба цаашдаа нийт хандивлагчаа байнгын хандивлагч болгох зорилт тавьж байна.

Талархал

Монголын Эмэгтэйчүүдийн Сангаас зохион байгуулсан бүх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө хандив өргөж сая сая хандивлагчдын эгнээнд нэгдэн орж байгаа хандивлагч хувь хүмүүс, байгууллага хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.



Филантропи өдрөөр хандив өргөж байгаа нь

88 өдрийн аяны хандивын хайрцаг



Филантропи өдөр

Олон улсын Филантропи өдрийг 4 дэх жилдээ "Нийгмийн сайн сайхан, хөгжил дэвшлийн төлөө хандив өргөцгөөе!" уриан дор 2006.11.08-15-ны өдрүүдэд тэмдэглэлээ.

Энэ жилийн хувьд хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран дараах үйл ажиллагаанууд зохион явагдлаа.

ОЛОН УЛСЫН ФИЛАНТРОПИ ӨДРҮҮД
2006.11.08-15
 Нийгмийн сайн сайхан хөгжил дэвшлийн төлөө
"ХАНДИВ" ӨРГӨЦГӨӨЕ

Зохион байгуулагч: **МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН /МОНЭС/**

Ивээн тэтгэгчид:
MNB **UBS** **TV8** **TM** **TV8**
SBN **mnv** **EAGLE** **C1 TV** **Боловсрол суваг TV**

Үүнд:

Өсвөр насны хүүхдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилготой ХЭҮТ /Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв/-тэй хамтран "Хүүхдийн хамгаалах байр"-нд хандив цуглуулах үйл ажиллагааг TV8, UBS телевизтэй хамтран зохион явууллаа. Үүний үр дүнд нийт 2.207.700 мянган төгрөгний хандив цуглуулсан.

Хэвлэлийн бага хурал хийж Филантропи өдрийг тэмдэглэн, "Нийгмийн сайн сайхан, хөгжил дэвшлийн төлөө хандив өргөцгөөе!" уриаг телевизын 10 сувгаар олон нийтэд хүргэлээ.



ОУ-ын Филантропи өдрүүдийг Монголд тэмдэглэн өнгөрүүлэхэд хамтран ажиллаж, үнэтэй хувь нэмэр оруулсан хэвлэл мэдээллийн байгуулагууддаа талархал илэрхийлье!

- Боловсрол суваг телевиз
- МҮОНТВ
- NTV
- TV8
- SBN
- MN25
- TM

- Eagle TV
- TV9
- TV5
- Өдрийн сонин
- Өнөөдөр сонин
- Залуусын Радио FM-102.1



Хамтын ажиллагаа

Бид Хаан банкны 10 салбарт байрлуулсан хандивын хайрцагаар 445935 төгрөг цуглуулж, архинд гүн хордсон эмэгтэйчүүдийг нийгэмшүүлэх, орлого нэмэгдүүлэх төслийн зардалд хувь нэмэр болгон зориуллаа. Энэ төсөлд нийт 1,8 сая төгрөг зарцуулсан бөгөөд төслийн үр дүнд архинд донтсон 20 эмэгтэй хорт зуршлаас гарч, гар урлал хийж суран орлого олох чадвартай боллоо.

Талархал

Хаан банкны хамт олон болон тус банкны хэрэглэгч Та бүхэндээ МОНЭС-ийн хамт олноос чин сэтгэлийн талархал дэвшүүлье.



ХААН БАНК



МОНЭС-ийн хамт олон

1. Удирдах Зөвлөл

МОНЭС-ийн Удирдах зөвлөл 23 гишүүнтэй.

ҮЗ-ийн гишүүдэд дараах хүмүүс байдаг.

Ш.Цэвэлмаа Тэргүүн
Б. Оюунбилэг Дэд Тэргүүн
Б. Наранцэцэг
Ш. Оюунгэрэл
Л. Амарзаяа
Н. Дуламсүрэн
Д. Наран
Ж. Алимманцэцэг
Т. Нямцэцэг
Д. Оюунцэцэг
Д. Амараа
Л. Болор

Т. Ундарьяа
С. Төгс-Оюун
Д. Нэргүй
Ө. Сарантуяа
С. Дондов
Б. Нандинчимэг
Д. Агиймаа
Х. Хулан
С. Оюунчимэг
Ш. Солонго
А.Энхцэцэг

2. Гүйцэтгэх Алба

Н.Чинчулуун
Д. Пүрэвсүрэн
Б.Байгалмаа
Ч.Ундрах
С.Цэрэнпүрэв

Захирал, үүсгэн байгуулагч
Дэд захирал
Хөтөлбөрийн зохицуулагч
Гадаад харилцааны ажилтан
Дотоод ажлын зохицуулагч

МОНЭС-ийн ажилтанууд шагнал хүртэв



Дотоод ажлын зохицуулагч С.Цэрэнпүрэв нь МОНЭС-ийг үүсэн байгуулагдсан цагаас эхлэн

өөрийн хүч хөдөлмөр, идэвхи зүтгэл, чин сэтгэлээсээ ажиллаж ирсэн амжилтыг үнэлж 2006 онд "Хүндэт өргөмжлөл"-өөр шагналаа.



Хөтөлбөрийн зохицуулагч Б.Байгалмаа нь нийгмийн сайн сайхан, хөгжил

дэвшлийн төлөөх үйл хэрэг болох филантропи үзэл хандлагыг нийгэмд шинээр түгээх үйлсэд оруулж буй хувь нэмрээрээ Нийслэлийн Тэргүүний залуу "Алтан медаль"-иар шагнагдлаа.



Сайн дурын гишүүд:

МОНЭС нь Сайн дурын үйл хэргийг хөхиүлэн дэмжиж, сайн дурынханы идэвхи хүч хөдөлмөрийн ачаар сан бүрдүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх олон талт ажлууд амжилттай хэрэгждэг.




Завханы төлөөлөгч Б. Цэрэндулам аймгийн эмэгтэйчүүдийн бүлгийн төлөөлөгчдийн идэвхи санаачлагыг өрнүүлж хамтарч ажилладаг.

Бид 10 аймагт сайн дурын төлөөлөгчтэй. Өнгөрсөн жил Завхан, Ховд аймгийн төлөөлөгчийн ажилд анхаарлаа хандуулан санал санаачлагыг нь дэмжиж ажиллалаа.

Орон нутгийн сайн дурын төлөөлөгч Б.Цэрэндулам 2006 оны Завхан аймгийн "ТББ-уудын Шилдэг ажилтан"-аар шалгарч Хүндэт тэмдэг, үнэ бүхий зүйлээр шагнагдав.



Намрын сан бүрдүүлэх кампанит ажил сайн дурынхны дэмжлэгээр амжилттай болсон.





ӨРГӨМЖЛӨЛ

Хүндэт МОНГОЛЫН
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САНГИЙН
ХАМТ ОЛОН Танаа

"Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх Олон улсын 16 хоногийн аяны-16 жил", Монгол Улсад тэмдэглэж эхэлсний 10 жилийн ойг тохиолдуулан Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахын төлөө үйлсэд бүтээлч идэвхи санаачлага гаргаж, бодитой хувь нэмэр оруулж буйг Тань үнэлэн Өргөмжилж байна.

Хүний эрхийг хамгаалах, нийгмийн хөгжилд хүйсийн тэгш оролцоог хангах үйлстээ улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе.


Монгол Улсын Ерөнхий сайд,
Жендэрийн тэгш байдлыг хангах
Үндэсний хорооны дарга

М.Энхболд

Улаанбаатар хот

2006.11.29

Санхүүгийн зарцуулалтын хувиарлалт





Хандивлагчдын нэрс

Хувь хандивлагчид /1-5000 төгрөг/

Cherryl Dunkerton	Батсайхан.н	Даваасүрэн. Н	Мөнхөө. Н	Оюундалай. И	Сүрэнхорлоо. Ш
Tanya Burkharott	Батсүрэн. Б	Даваасүрэн. С	Мөнхөө.н	Оюундэлгэр. Б	Сүхбат. Л
Valentin	Батсүрэн. Ж	Дариймаа. Ч	Мөнхтулга. Ц	Оюунжаргал. Б	Сэвхээ. Д
Алимаа. Ц	Батсүх. П	Дарханбаяр. Б	Мөнхтуяа. Т	Оюунсүрэн. Ц	Сэлэнгэ. Л
Алиманцэцэг. Ж	Батсүх.Д	Дарханбаяр. Э	Мөнхцэцэг	Оюунтунгалаг. Б	Сэргэлэн. Т
Алтай. Г	Баттулга. Х	Даш.н	Мөнхцэцэг. Д	Оюунтунгалаг. Ц	Сэржмаа.Ч
Алтан. Б	Батцэцэг. Г	Долгорсүрэн. М	Мэндбаяр. Ч	Оюунтуяа. Б	Төмөрбаатар. Д
Алтансүвд.н	Батцэцэг.н	Долгорсүрэн.н	Мэнджаргал. Д	Оюунхүү. Ж	Төмөр-Очир.Ж
Алтансүх. Ж	Бат-Эрдэнэ.Д	Должинсүрэн. Ж	Намсрайжав. Л	Оюунцэцэг. М	Төмөрхүү. Д
Алтантөгс. Л	Баянтүмэн	Дорж. Б	Нансал. Ц	Оюунцэцэг. С	Төрбадрах. Т
Алтантуяа. Б	Баяраа. Ч	Дөлгөөн. Э	Нарангарав. Н	Оюунчимэг. Г	Түвшин.Ж
Алтантуяа. М	Баярмаа. М	Дулам. П	Нарангэрэл. Л	Оюунчимэг. Д	Түвшинбаатар. Б
Алтантуяа. О	Баярсайхан. Б	Дуламжав. М	Нарангэрэл. С	Оюунчимэг. Ж	Түмэнжаргал. Ц
Алтанхүү. Ж	Баярсайхан.Б	Дуламханд. Н	Нарангэрэл. Я	Оюунчимэг. Н	Тунгалаг.н
Алтанцэцэг. Н	Баяртогтох. Г	Дулмаа. С	Нарантунгалаг. Р	Оюун-Эрдэнэ. Н	Тунгалагтуяа. Б
Амараа.н	Баясгалан. Б	Дулмаа.Ц	Нарантуяа. Р	Өгөөмөр. Б	Тунгалагтуяа. Х
Амарбаясгалан. Д	Билэгмаа. Н	Дунбүрээ. Г	Нарантуяа. Ч	Өлзийсүрэн. А	Туяа. Ж
Амаржаргал. Д	Болд. Ц	Дэлгэрмаа. Т	Нарантуяа.Б	Өлзий-Учрал. Б	Туяа. Ц
Амаржаргал. Ж	Болдбаатар. Л	Дэлгэрцог. Д	Наранцэцэг. П	Өнөрцэцэг.Г	Туяагэрэл. С
Амарсанаа. Э	Болормаа. П	Жавзансүрэн. С	Наранцэцэг. Я	Өсөхбаяр. Х	Туяажаргал. Б
Амгалан. Д	Болормаа. С	Жаргалсайхан. Ю	Нармандах. А	Өсөхболд. Э	Тэгшжаргал. Т
Аня. Б	Болорцэцэг.Ж	Загарзүсэм. П	Нармандах. Б	Пагмажав. О	Удаанжаргал. М
Ариунаа. Н	Бороо. Х	Заяабаяр. Б	Нармандах. Д	Пүрэвдорж. М	Ундрах. Ч
Ариунаа. Н	Бөхчулуун. Г	Золбоо. Ч	Нина. Г	Пүрэвжаргал. Т	Уранбилэг
Ариунзул.н	Буддорж. Э	Золзаяа. Л	Нина. Я	Пүрэвням. Ч	Уранбилэг. Д
Ариунцэцэг. Д	Бурмаа. П	Золзаяа. О	Нинжин. О	Пүрэвсүрэн. П	Урантогос. Д
Баасандорж. Д	Бүрэнтөгс. Н	Золзаяа. Ц	Норжинжав. Л	Пүрэвсүрэн. Д	Уранчимэг. Д
Баасанжав. Б	Бямбасүрэн	Зоригтбаатар. Д	Норжинлхам. Ц	Пэлжидмаа. Б	Уранчимэг. Р
Баасанжав. С	Бямбасүрэн.Ж	Идэрээ.н	Норовцэрэн. С	Рэгзэнхорлоо. С	Уранчимэг. Э
Баасанхүү. П	Бямбацогт. Д	Ичинхорлоо. Ц	Нэмэх. и	Сайнбаяр. Ц	Уртнасан. Г
Баатарчулуун.Г	Галсанжав. А	Лувсанчүлтэм. В	Нямхүү. Ж	Сайнжаргал.Т	Ууганбаяр. О
Бадам. С	Ганбаатар. Ч	Лутхад. Б	Нямхүү. М	Сандагсүрэн.П	Ууганцэцэг. М
Бадамгарав. П	Ганболд. С	Лхагважав. М	Нямцэвэл. Б	Санжжав. Ш	Үүрийнцолмон.Б
Бадамцэцэг. Ш	Ганбүргэд. Л	Лхагважав.н	Нямцэцэг. Ч	Сарангэрэл	Уянга. Э
Бадамцэцэг.Ц	Ганзориг.Б	Лхагвасүрэн. Ш	Одгэрэл	Сарантуяа. З	Хандсүрэн.н
Бадрууш. Д	Гантулга. Д	Лхамсумьяа. Л	Одгэрэл. Б	Саранцэцэг. С	Хатанхэрлэн.Б
Балжинням. Ц	Гантуяа. О	Лхамсүрэн. Л	Одгэрэл. Г	Сарнай. Ж	Хорлоо. Д
Банзай	Ганхуяг. С	Лхам-Эрдэнэ. Г	Одонбаатар. Т	Саруул. А	Хоролгарав.П
Батаа. и	Ганчимэг. Д	Манвал. Д	Одонтуул. Т	Соёлмаа. Б	Хоролсүрэн. И
Батбаатар.н	Ганчимэг. Д	Мандал. Б	Одончимэг.Н	Соёлмаа. Д	Цогзол. Д
Батболд. Т	Ган-Эрдэнэ. Д	Мандах. О	Орсоо. Ж	Соёлмаа.н	Цогзол. Л
Батболд.н	Гөлгөө. З	Мишээл. Д	Отгон. и	Соёл-Эрдэнэ.Б	Цогзол. П
Батжаргал. Г	Гучин. Х	Мөнгөн-Од. Б	Отгонбаяр. О	Сонинпил. Г	Цогзолмаа. Л
Батжаргал. П	Гэжидмаа. Д	Мөнгөнтулга. С	Отгонбаяр. Ч	Сосорбарам. Д	Цогзолмаа. У
Батжаргал. Ш	Гэрлээ. Г	Мөнгөнтулга. Ц	Отгонбаяр.Д	Сосоржав.Д	Цэвээн. Т
Батзаяа. Ж	Гэрэлсүрэн. Н	Мөнгөнцоож.М	Отгонтуяа. Б	Сувд. Д	Цэвээндулам. Б
Батзаяа. Ц	Гэрэлсүрэн. Н	Мөнхбаатар. Л	Очирбат. Д	Сувдаа. Х	Цэвээсүрэн.Д
Батзориг.Б	Гэрэлхүү	Мөнхбат. Н	Оюун. Б	Сувдмаа. М	Цэдэнбал. Н
Батмөнх. Г	Гэрэлцацрав. Д	Мөнхжаргал. П	Оюун. Ц	Сувд-Эрдэнэ. С	Цэндсүрэн. Ц
Батсайхан	Давааням. Ч	Мөнхжаргал. Х	Оюунбүрэн. Т	Сүндэрмаа. Б	Цэрмаа. Д
Батсайхан. Б	Даваасүрэн. Д	Мөнхжаргалан. М	Оюунгэрэл. Ш	Сүрэн. Ш	Цэрмаа.Г

Цэрэндагва н	Цэцэгсайхан. О	Энхжаргал. Г	Энхтуяа. Д	Эрдэнэцогт. Л
Цэрэндолгор. Ц	Чанцалням. Б	Энхжаргал. Ц	Энхтуяа. Ш	Эрдэнэцэгцэг. Д
Цэрэндорж. С	Чимэдцэвээн. М	Энхжин. Д	Энхцэцэг. Г	Эрдэнэцэгцэг. Ш
Цэрэндүг. Н	Чингүүн. А	Энхсайхан. Т	Энхцэцэг. А	Эрдэнэчимэг
Цэрэндунлам. Б	Чулуунбаатар. н	Энхсайхан. Ж	Энхчулуун. Г	Эрдэнэчимэг. Б
Цэрэндэжид. Д	Чулуунхүү. О	Энхтайван. Б	Энэбиш. Б	Эрдэнэчимэг. н
Цэрэннадмид. Э	Үрэнчимэг. Ш	Энхтайван. О	Эрдэнэболор	Эрдэнээ. Н
Цэрэнханд. Б	Энхбат. Г	Энхтайван. Х	Эрдэнэсүрэн. Б	Юмчин. н
Цэрэнпүрэв. С	Энхбат. Ц	Энхтүвшин. Л	Эрдэнэтуяа. и	Янжинлхам
Цэцэгээ. Л	Энхбуйр. А	Энхтуул. М	Эрдэнэтуяа. Х	Янжинлхам. Г
Цэцэгмаа. Б	Энхжаргал. Г	Энхтуяа. Б	Эрдэнэтуяа. Б	

Хандивлагч байгууллагууд /1-5000 төгрөг/

“Чифури” гоо сайхны дэлгүүр
1-р сургуулийн 11в ангийн хамт олон
97-р сургуулийн хамт олон
AWID ОУБ
MCS coca cola
Solid SystemsLLC
Автотээвэр ХБҮ-4-р хэсэг
Адра ОУБ
Ариун ертөнц нийгэмлэг
Багануур дүүргийн 4-р хороо
Баян-Өлгий аймгийн НААҮ-ний СУАТ ХК
хамт олон
Баян-илгий аймгийн Холбооны хамт олон
Баян-Уул Инвест дэлгүүр
Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Холбоо
Болор саун
Булган аймгийн Магнай Трейд ХХК-ны
салбар
Булган аймгийн МСҮТөв
Булган аймгийн Онцгой байдлын хэлтэс
Булган аймгийн Прокурор
Булган аймгийн ХЭАХН
Булган аймгийн Цанлэг эмнэлэг

Булган аймгийн Шүүх
Голомт банкны маркетингийн алба
Гэрэлтмандах ӨНЭ
Дорнын говь ХХК
ДОХ-той тэмцэх сан
Дулаанханы 8 жилийн сургуулийн хамт
олон
Дулаанханы Захиргаа
Дулаанханы Хүний эмнэлэгийн хамт олон
Дулаанханы Цэцэрлэгийн хамт олон
Дүүрэн Санаа төв
Засгийн Газрын Усны хэрэг эрхлэх газарт
ЗХЖТ-ийн дэргэдэх НЭМБТ СХД-З хороо
Зэвсэгт хүчний 124-р анги
Инфо сонин
Ирээдүйн гарц ТББ
Консенсус ТББ
ЛЭОС-ийн Булган аймгийн салбар
Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв
МХЗХС
Номадс Леженс ресторан
Опен Хаус ХХК

Отгонтэнгэр Дээд Сургуулийн Европ хэлний
тэнхим
Отгонтэнгэр Дээд Сургуулийн Нийгмийн
ухааны тэнхим
Отгонтэнгэр Дээд Сургуулийн ОДХ-ний
тэнхим
Отгонтэнгэр Дээд Сургуулийн Эдийн
Засгийн Тэнхим
Өдрийн сонин
Соёмбо ХХК-ны дэвтэрлэгээ
Соёмбо ХХК-ны Эх бэлтгэл
Хатан Сүлжээ ХХК
Ховд аймгийн ҮЭ-ийн холбооны хамт
олон
ХЭҮТ-ийн Дархан-уул аймгийн салбар
Элба BSB сервис
ЭМСТөв
Эрдэнэт хотын АЗДТГ
Эрдэнэт хотын Халамж Үйлчилгээний Төв
Эрдэнэт хотын Экспусс лаборатори
Эрдэнэт хотын Эрко хувийн эмнэлэг
Эрүүл Мэндийн Байгууллагуудын ҮЭХ
Эрүүл Мэндийн Нийгэмлэг

Хувь хандивлагчид /5001-10. 000 төгрөг/

Abigail Willmer	Амаржаргал. Д	Баттулга. О	Ганчимэг. Д	Жавзандулам. С	Мөнгөнцэцэг. Д
Alex	Амаржаргал. З	Батцэрэн. М	Ган-Эрдэнэ. Г	Жаргал. Т	Мөнхбүрэн. Д
Carol Beaiesto	Амарсайхан. Б	Батчулуун. Н	Гүнжээ. Ж	Жаргал. Ч	Мөнхдэлгэр. С
Evelyn Cubelo	Амарсайхан. П	Баяраа. М	Гэнэндулам. Ж	Жаргалан. А	Мөнхжаргал. Т
Lizzie Wiltshirer	Ананд. Ч	Баяржаргал. Н	Гэрэлмаа. Я	Жаргалмаа. Ж	Мөнхтулга. н
Marielle Grit	Анударь. Г	Баярмаа. Б	Гэрэлсүрэн. Н	Жигжид. Ш	Мөнхтуяа. Б
Nikkie Oldman	Ариунболор. Д	Баярцогт. Д	Гэрэлтуяа. О	Занаа. Ж	Мөнххишиг. Ц
Wanbun. Но	Ариунтөгс. Ц	Биндэрьяа. Д	Гэрэлтуяа. Ц	Золжаргал. Ж	Мөнхчулуун. Г
Алимаа. Д	Ариунтунгалаг. Ч	Биндэрьяа. Г	Гэрэлхүү. Г	Золжаргал. С	Нандинсүвд. Б
Алтангэрэл. Г	Аюуш. Б	Болорцэцэг. Б	Даваа. Б	Зулаа. н	Нансалмаа. П
Алтандуулга. Б	Баасанхүү. Ж	Болорцэцэг. Ж	Даваадагва. Д	Зулгэрэл. Д	Наран. Д
Алтанцэцэг. Ц	Бадамдулам. Г	Болорчулуун. Э	Даваасүрэн. С	Инамсрай. А	Нарантуяа. Д
Амараа. Д	Бадамсүрэн. Д	Булган. Б	Дариймаа. Н	Ичинноров. М	Нарантуяа. Ш
Амарбаясгалан. Б	Бадамцэцэг. Л	Бүлтэн. Б	Дарханбаяр. Ж	Ичинхорлоо. Б	Нарантуяа. Н
	Бадрах. П	Бумандорж. Л	Дашдондов. З	Ичинхорлоо. Б	Наранцэцэг. Ж
	Байгалмаа. Б	Бунд-Очир. Д	Дуламсүрэн. А	Лхагва. Д	Наранцэцэг. Ч
	Байгалмаа. Д	Бурмаа. Д	Дуламсүрэн. Н	Лхагваням. Б	Наранцэцэг. Ц
	Байгалмаа. Ц	Буянаа. н	Дуламсүрэн. П	Лхагвасүрэн. Б	Наранцэцэг. н
	Батбаяр. З	Бэхбат. Б	Дулмаа. Л	Лхагвасүрэн. М	Наранчимэг. Т
	Батжаргал. Г	Бямбасүрэн. С	Дулмаа. Р	Лхагвасүрэн. н	Наранчимэг. Д
	Батмөнх. Б	Бяцхандай. Ж	Дэлгэр. Ж	Лхамдулам. Н	Наранчимэг. н
	Баттөмөр. Д	Ганбаясах. Г	Дэлгэрмаа. Б	Мандхайцэцэг. У	Насандэлгэр. Д
	Баттулга. Б	Ганзориг. Д	Дэлгэрмаа. Ч	Марта. н	Нэргүй. Д
	Баттулга. Г	Гантулга. Д	Ерөөлсүрэн. Ч	Мөнгөндуулга. Д	Нэргүй. М



Та бидний үйл хэргийг дэмжиж хандив өргөнө үү.

Хандиваа дараахь хэлбэрээр өргөх боломжтой.

- Дансаар
- Холбоо тогтоох /утасдах, интернэтээр харьцах, биеэр ирж уулзах гэх мэт/

1. Данс

Дотоод:

- Худалдаа хөгжлийн банк
/З-р салбар/ Бага тойруу салбар
Төгрөгийн данс: 453016378
Гадаад валютын данс: 453023942

- ХААН банкны /Спортын ордын салбар/
Төгрөгийн данс: 5031039208

Гадаад:

1. Хэрвээ та Америкт сурч, ажиллаж байгаа бол Америкийн Give to Asia ба Global Fund for Women /Дэлхийн Эмэгтэйчүүдийн сан/ гэсэн байгууллагуудаар дамжуулан хандиваа өргөж болно. Энэ байгууллагууд нь 501 С бүртгэлтэй ба та хандиваа Америкаас явуулж байгаа бол танд татварын хөнгөлөлт үзүүлнэ.

Хаяг: www.give2asia.org
www.globalfundforwomen.org

2. Correspondent Bank - HSBC BANK USA, NEW YORK, USA

SWIFT: MRMDUS33
Account No: 0000304298

Beneficiary's Bank - TRADE AND DEVELOPMENT
BANK OF MONGOLIA, ULAANBAATAR, MONGOLIA
SWIFT: TDBM MN UB,
Account No: 453023942



МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН
MONGOLIAN WOMEN'S FUND

**ТА МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛ
ДЭВШЛИЙН ТӨЛӨӨ ХАНДИВ ӨРГӨНӨ ҮҮ!**

**MAKE A DONATION TO SUPPORT
MONGOLIAN WOMEN'S PROGRESS**

Биднийг дэмждэг байгууллагуудад


ТАЛАРХАЛ ДЭВШҮҮЛЬЕ!



GLOBAL FUND
FOR WOMEN

filia
die frauenstiftung.

Iara Lee & George Gund Foundation



grantmakers
WITHOUT BORDERS




WOMEN'S FUNDING NETWORK
CHANGING FACE OF PHILANTHROPY



BRITISH EMBASSY



stiftung
natur
mensch
KULTUR



TIDES

FOUND A T I O N

**URGENT
ACTION
FUND** ♀

FOR WOMEN'S HUMAN RIGHTS